

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## **Агуулга**

Агуулга .....	1
1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Зорилтод түвшин, гүйцэтгэлийн тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	8
3. Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	13
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18

## **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БАГАНУУР ТООСГО  
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Э.ДАШРАВЖИР ТАНАА

2020.03.13 № 06/848  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал

Тайлант онд Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар Багануур тоосго ТӨААТҮГ нь эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж ажиллаагүй, 43.1 сая төгрөгний алдагдалтай ажилласан зөрчил гаргаж, санхүүгийн тайлангийн Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага


Багануур тоосго ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Э.Дашравжир Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйл ажиллагааны онцлогтоо тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах, бэлэн мөнгөний тооллого хийж тооцоог бодож байх, анхан шатны бүртгэлийн маягтыг холбогдох заавар, журмын дагуу хөтөлж хэвших зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төрийн өмчит үйлдвэрийн газар санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 09-өөс 2020 оны 03 дугаар сарын 03-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Багануур тоосго ТӨААТҮГ-т хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитын анхан шатны чанарын хяналтыг захирал Ж.Цэцэгмаа, аудитыг аудитор С.Дашдондог, аудиторын туслах Г.Ундармаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 019/38 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АОУС, АДББОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Багануур тоосго ТӨААТҮГ нь үйл ажиллагааны зорилгоо “ШШГЕГ-ын хорих ангид ял эдэлж байгаа хоригдлуудыг тус үйлдвэрт ажиллуулснаар улсад болон иргэнд учруулсан гэм хорыг ажлын хөлсөөр нь барагдуулах болон арьсан эдлэл хийх арга барилд сургаж, хоригдох хугацаанд нь хөдөлмөр эрхлүүлэн нийгэмшүүлэх” гэж тодорхойлжээ.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын тайлант онд үйлдвэрийн чанар, стандарт хангасан тоосго, блокыг үйлдвэрлэн, хоригдлыг цалинтай ажлын байраар хангаж, тэдний үйлдсэн гэмт хэргийн улмаас бусдад учруулсан гэм хорын төлбөрийг барагдуулах, ШШГЕГ-ын харьяа анги салбар болон Багануур дүүрэг, иргэд аж ахуй нэгжийг хямд үнэтэй бүтээгдэхүүнээр хангах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг чандлан сахих жил болгон зорилт тавин ажилласан байна.

Багануур тоосго ТӨААТҮГ нь Монгол улсын засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 2/351 дүгээр тогтоолоор байгуулагдаж, улаан тоосго, блок үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 тоот “Журам батлах тухай” тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 25 тоот “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 тоот “Төрийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Багануур Тоосго ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь ШШГЕГ-ын хэмжээнд хийгдсэн “нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” байгаа бөгөөд “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон бодлого журам боловсруулж, мөрдөж ажиллаагүй байна.

Багануур тоосго ТӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Unicus” программ хангамж ашигладаг байна.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Багануур тоосго ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд 8 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 121.2 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 2.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2.4 сая төгрөгөөр тооцсон нь зардлын данстай эрсдэл илэрсэнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19.3 сая төгрөгөөр буюу 7.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	28.5	3.9	(24.6)
Авлага	22.3	20.6	(1.7)
Бараа материал	8.4	40.6	32.2
Үндсэн хөрөнгө	207.7	182.9	(24.8)
Биет бус хөрөнгө	0.8	0.5	(0.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>267.8</b>	<b>248.5</b>	<b>(19.3)</b>
Дансны өглөг	-	14.4	14.4
Татварын өр	0.1	0.1	
Богино хугацаат өр төлбөр	-	9.6	9.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	192.3	192.3	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	117.7	117.7	-
Хуримтлагдсан ашиг	(42.3)	(85.4)	(43.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>267.8</b>	<b>248.5</b>	<b>(19.3)</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 24.6 сая төгрөгөөр буурсан нь тайланд онд Багануур тоосго ТӨААТҮГ нь алдагдалтай ажиллаж, орлого бууран зарлага гарснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 1.7 сая төгрөгөөр буурсан нь хувь хүнээс авах авлагыг барагдуулсан. Авлагын үлдэгдэлд 19.4 сая төгрөг нь Ханбаян ХХК-аас авах авлагыг шийдвэрлүүлэхээр Хан-Уул дүүргийн иргэний хэргийн шүүхэд хандсан байна.

НӨАТ-ын авлага 1.2 сая төгрөг нь Багануур дүүргийн татварын албаны тайлангаар баталгаажсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 32.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны эцэст борлогдоогүй бэлэн бүтээгдэхүүний /тоосго/ чанарын шаардлага хангаагүй үлдэгдэл бий болсноос шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24.8 сая төгрөгөөр буурсан нь 29.7 сая төгрөгийн элэгдэл байгуулснаар хорогджээ. Тайлант онд 4.9 сая төгрөгийн блокны машин шинээр худалдаж авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь ШШГЕГ-аас 9.6 сая төгрөгийн ажиллагсдын цалин олгохоор зээл авсан, хоригдлуудын олгогдоогүй цалин хөлс 14.3 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Хуримтлагдсан ашиг 43.1 сая төгрөгөөр буурсан нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн чанарын шаардлага хангахгүйгээс борлогдоогүй 34.4 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн /тоосго/ үлдсэнтэй холбоотой байна.

## 2.9. Зорилтод түвшин, гүйцэтгэлийн тайлбар, тодруулга

Зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг

Багануур тоосго ТӨААТҮГ-ын тайлант онд 216.7 сая төгрөгийн орлого бүдрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 115.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 101.1 сая төгрөгөөр буюу 53.3 хувиар орлогын төлөвлөгөөг тасалдуулсан байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө дүн	Гүйцэтгэл дүн	Зөрүү	Хувь
<b>Борлуулалтын орлого</b>	<b>216.7</b>	<b>115.6</b>	<b>(101.1)</b>	<b>53.3</b>
<b>Борлуулалтын өртөг</b>	<b>120.6</b>	<b>51.8</b>	<b>(68.8)</b>	<b>42.9</b>
<b>Нийт ашиг/алдагдал</b>	<b>96.1</b>	<b>63.8</b>	<b>(32.3)</b>	<b>66.3</b>
Түрээсийн орлого		1.5	1.5	
Хүүгийн орлого		0.3	0.3	
Борлуулалт маркетингийн зардал		2.2	2.2	
Ерөнхий удирдлагын зардал	66.5	98.1	31.6	147.5
Дээд байгууллагад төвлөрүүлэх	20.0	20.0	-	100.0
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	34.5	(43.1)	(77.6)	(124.9)
Орлогын татварын зардал	3.4	0.03	(3.37)	0.8
<b>Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал</b>	<b>31.1</b>	<b>(43.1)</b>	<b>(77.6)</b>	<b>(124.9)</b>

/сая төгрөг/

Багануур тоосго ТӨААТҮГ нь орлого тасалдуулсан гол шалтгаан нь Тоосгоны үйлдвэрт ажилладаг мэргэжилтэн байхгүй. Үйлдвэрлэсэн тоосго нь чанарын хувьд гологдол болж байгаатай шууд холбоотой байна.

Тайлант оны эцэст 31.5 сая төгрөгийн 460 гаруй мянган тоосго үйлдвэрийн хашаанд хураалттай байна.

2019 онд ШШГЕГ-аас өгсөн удирдлагын зардлын төлөвлөгөөний биелэлтийн тодруулга:

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал	40.0	56.6	16.5	141.2
Бараа үйлчилгээний зардал	17.4	36.5	19.1	210.0
Хөрөнгө оруулалтын зардал	3.0	4.9	1.9	163.3
Нөөцийн сан	6.0		(6.0)	
Нийт дүн	66.5	98.1	31.6	147.5

/сая төгрөг/

Багануур тоосго ТӨААТҮГ нь 2019 онд ерөнхий удирдлагын зардалд 66.5 сая төгрөгийн төлөвлөгөөтэй боловч гүйцэтгэлээр 98.1 сая төгрөгийг зарцуулж төлөвлөгөөг 31.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 тоот “Төрийн албан тушаалын цалингийн сүлжээ хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын дагуу үйлдвэрлэл зогсоосон үеийн албан тушаалын сарын үндсэн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр бодож олгосноос шалтгаалан 16.5 сая төгрөгөөр цалингийн сан хэтэрсэн.



- Бараа үйлчилгээний зардлын төлөвлөгөөнд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн элэгдлийг оруулаагүйгээс бараа үйлчилгээний зардал 19.1 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Хөрөнгө оруулалтын зардал дансны үлдэгдэл 1.9 сая төгрөгөөр өссөн нь 4.9 сая төгрөгөөр блокны машин авснаас шалтгаалжээ.

**Хандив тусламжаар авсан хөрөнгө оруулалт:** Тайлант онд 4.8 сая төгрөгийн хоригдлын ажлын хувцсыг ШШГЕГ-аас хандиваар үнэ төлбөргүйгээр авч хангамжийн материалын дансанд орлого болгосон байна.

Дээд шатны байгууллагад төвлөрүүлэх хөрөнгийг буюу төсөвлөсөн 20.0 сая төгрөгийг ШШГЕГ-ын дансанд төвлөрүүлэн оруулсан.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд эрсдэлгүй гэж тодорхойлон нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 44.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 44.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 44.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 8 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарах татахуйц бусад асуудал байхгүй.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Багануур тоосго ТӨААТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 20.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан, хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, дүрэм, журам СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч. түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

*Багануур тоосго ТӨҮГ нь ШШГЕГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг. Тус баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2."Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.*

##### **3.1.2 Эрсдэл:**

*Санхүүгийн тайлан, бүртгэл буруу илэрхийлэгдэх, холбогдох стандарт, хууль, журам зааврыг мөдөж ажиллаагүй байх;*

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

*Байгууллагынхаа онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж, ажиллах.*

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

*Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

#### **3.2 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

*Бэлэн мөнгөний үлдэгдэл 0.01 сая төгрөгийг зохих хууль журмын дагуу тооллого хийгээгүй, кассын тайланг цаг тухайд нь гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6."эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.*

##### **3.2.2 Эрсдэл:**

*Мөнгөн хөрөнгө дутагдах, шамшигдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх*

**3.2.3 Өгсөн зөвлөмж:**

*Бэлэн мөнгөний үлдэгдлийг хууль, дүрэм журмын тооллого хийж тооцоо бодож байх.*

**3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

*Зөвлөмжийг мөрдөн ажиллана.*

**3.3 Балансын данстай холбоотой асуудал**

**3.3.1 Илрүүлэлт:**

*Үйлдвэрлэлийн дамжлагын тайлан гаргаагүй Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4."Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага. нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтад нийцээгүй. (34.4 сая төгрөг)*

**3.3.2 Эрсдэл:**

*Үйлдвэрлэлийн дамжлагад хөрөнгө дутагдах, дамжлагын дундах бүртгэл тооцоо тохирохгүй байх;*

**3.3.3 Өгсөн зөвлөмж:**

*Үйлдвэрлэлийн дамжлагын бүртгэлийг хөтөлж, тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж хэвших.*

**3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

*Зөвлөмжийг мөрдөн ажиллана.*

**3.4 Балансын данстай холбоотой асуудал**

**3.4.1 Илрүүлэлт:**

*Багануур тоосго ТӨҮГ нь 4 автомашинтай бөгөөд тухайн автомашинуудад техник ашиглалтын паспорт хөтлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.*

**3.4.2 Эрсдэл:**

*Сэлбэг хэрэгсэл болон засвар үйлчилгээнд бүртгэлээр тавих хяналт байхгүй болно*

**3.4.3 Өгсөн зөвлөмж:**

*Бүх авто машиндаа техник ашиглалтын паспортыг хөтөлж, хувийн хэрэг нээн сэлбэгийн болон шатахууны бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших*

**3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

*Зөвлөмжийг мөрдөн ажиллана.*

**3.5 Балансын данстай холбоотой асуудал**

**3.5.1 Илрүүлэлт:**

*Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан 19.3 сая төгрөг авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтыг мөрдөөгүй.*

**3.5.2 Эрсдэл:**

*Найдваргүй авлага үүсч байгууллагад алдагдал учирна.*

**3.5.3 Өгсөн зөвлөмж:**

*Авлагын үлдээдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулж, барагдуулах*

**3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

*Зөвлөмжийг мөрдөн ажиллана.*

**3.6 Зардлын данстай холбоотой асуудал**

**3.6.1 Илрүүлэлт:**

*Шатахууны зардлыг зорилтот түвшний төлөвлөгөөнөөс 1.3 сая төгрөгөөр хэтрүүлэн, шатахууны тооцоо бодож тайлан гаргаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах". Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудад нийцэхгүй байна.*

**3.6.2 Эрсдэл:**

*Төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулах*

**3.6.3 Өгсөн зөвлөмж:**

*Шатахууны тайланг үнэн зөв гаргаж, хэтрэлт хэмнэлтийг тооцож ажиллаж*

**3.6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

*Шатахуун зарцуулалтын тайланг гаргаж, тооцоог тухай бүр бодож хэвшинэ.*

**3.7 Зардлын данстай холбоотой асуудал**

**3.7.1 Илрүүлэлт:**

*2019 оны борлуулалтын орлогыг 101.1 сая төгрөгөөр ашгийн төлөвлөгөөг 43.1 сая төгрөгөөр тус тус тасалдуулсан . Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага нь "эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, зорилтот түвшинд хүргэх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.*

**3.7.2 Эрсдэл:**

*Төрийн өмчит Байгууллага алдагдалд орж дампуурах эрсдэл үүснэ*

**3.7.3 Өгсөн зөвлөмж:**

*Зорилтот түвшингийн гэрээний үүргээ биелүүлэх*

**3.7.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

*Зөвлөмжийг мөрдөн ажиллана*

**3.8 Зардлын данстай холбоотой асуудал**

**3.8.1 Илрүүлэлт:**

*Шилэн дансны 24 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.*

**3.8.2 Эрсдэл:**

*Мэдээллийн хэрэглэгчдэд цаг хугацаандаа хүрэхгүй байх, мэдээллийн ил тод байдлыг хангаагүй, холбогдох хууль, журам зааврыг мөрдөж ажиллаагүй байх;*

3.8.3 Өгсөн зөвлөмж:

*Шилэн дансны тухай хуулийн 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалтыг мөрдөн хэрэгжүүлэх.*

3.8.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

*Зөвлөмжийг мөрдөн ажиллана*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	28,512,675.12	3,916,250.01
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	84,281.81	1,222,562.51
1.1.4	Бусад авлага	22,268,500.00	19,358,500.00
1.1.6	Бараа материал	8,400,507.42	40,601,335.63
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>59,265,964.35</b>	<b>65,098,648.15</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	207,735,946.85	182,896,723.63
1.2.4	Биет бус хөрөнгө	762,820.56	501,282.12
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>208,498,767.41</b>	<b>183,398,005.75</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>267,764,731.76</b>	<b>248,498,653.90</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг		14,362,974.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	125,055.54	26,628.32
2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат бусад өр төлбөр		9,562,781.76
2.1.1.6	Хүүний өглөг		
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>125,055.54</b>	<b>23,952,384.08</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>125,055.54</b>	<b>23,952,384.08</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	192,291,669.83	192,291,669.83
2.3.2	- хувийн		
2.3.3	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	117,668,893.04	117,668,893.04
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(42,320,886.65)	(85,416,293.05)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>267,639,676.22</b>	<b>224,544,269.82</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>267,764,731.76</b>	<b>248,498,653.90</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>172,335,334.57</b>	<b>115,589,963.68</b>
2	Борлуулалтын өртөг	78,506,655.82	51,818,668.26
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>93,828,678.75</b>	<b>63,771,295.42</b>
4	Түрээсийн орлого	1,499,999.99	1,472,727.27
5	Хүүгийн орлого	490,637.26	266,283.25
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт. маркетингийн зардал	3,697,990.92	2,246,763.64
10	Ерөнхий ба удирдлагын зардал	67,684,212.90	98,061,866.98
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(6,643,152.83)	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)	16,731,321.63	(8,270,453.40)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>34,525,280.98</b>	<b>(43,068,778.08)</b>
19	Орлогын татварын зардал	49,063.73	26,628.32
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>34,476,217.25</b>	<b>(43,095,406.40)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>34,476,217.25</b>	<b>(43,095,406.40)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>34,476,217.25</b>	<b>(43,095,406.40)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>226,062,480.00</b>	<b>175,704,134.00</b>
1.1.1	Бараа борлуулсан. үйлчилгээ үзүүлсний орлого	220,170,380.00	158,827,160.00
1.1.2	Эрхийн шимтгэл. хураамж. төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас. санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	5,892,100.00	16,876,974.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>199,267,315.61</b>	<b>180,566,642.36</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	76,724,013.28	79,963,910.26
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,429,411.82	2,794,696.98
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	14,662,597.50	42,820,783.20
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,409,603.00	6,572,000.00
1.2.5	Түлш шатахуун. тээврийн хөлс. сэлбэг хэрэгсэлд төлсөн	26,613,440.00	35,148,104.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	23,435,376.01	16,636,727.92
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	210,150.00	309,420.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	50,782,724.00	2,321,200.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>490,637.26</b>	<b>266,283.25</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл. мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	490,637.26	266,283.25
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
3.1.1	Зээл авсан. өрийн үнэт цаас гаргаснаас		



Багануур тоосго ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

	хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>15,000,000.00</b>	<b>20,000,000.00</b>
3.2.1	Зээл. өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	15,000,000.00	20,000,000.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>4</b>	Валютын ханшийн зөрүү		
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>12,285,801.65</b>	<b>(24,596,425.11)</b>
<b>6</b>	<b>Мөнгө. түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>16,226,873.47</b>	<b>28,512,675.12</b>
<b>7</b>	<b>Мөнгө. түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>28,512,675.12</b>	<b>3,916,250.01</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>192,291,669.83</b>		<b>(76,797,103.9)</b>	<b>115,494,565.93</b>
2	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилт		117,668,893.04		117,668,893.04
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			34,476,217.25	34,476,217.25
4	Өмчид гарсан өөрчлөлт				
5	<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>192,291,669.83</b>	<b>117,668,893.04</b>	<b>(42,320,886.65)</b>	<b>149,970,783.18</b>
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(43,095,406.40)	(43,095,406.40)
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>192,291,669.83</b>	<b>117,668,893.04</b>	<b>(85,416,293.05)</b>	<b>224,544,269.82</b>

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	<b>Аудитын нэр:</b>	<i>Санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит</i>
2020.03.09	<b>Аудитын код:</b>	
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Багануур тоосго ТӨААТҮГ</b>	
<b>сая төгрөгөөр</b>		

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	З	4	5	9	10
1	Багануур тоосго ТӨҮГ нь ШШГЕГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг. Тус баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Заяажаргал
2	Бэлэн мөнгөний үлдэгдэл 0.01 сая төгрөгийг зохих хууль журмын дагуу тооллого хийгээгүй, кассын тайланг цаг тухайд нь гаргаагүй байна.	0.1	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Заяажаргал
3	Үйлдвэрлэлийн дамжлагын тайлан гаргаагүй		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Заяажаргал
4	2019 оны борлуулалтын орлогыг 101,1 сая төгрөгөөр ашгийн төлөвлөгөөг 43,1сая төгрөгөөр тус тус тасалдуулсан	43.1	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Заяажаргал
5	Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй. хөтлөлтийг цаг хугацаанд нь оруулаагүй.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Заяажаргал
6	Багануур тоосго ТӨҮГ нь 4 автомашинтай бөгөөд тухайн автомашинуудад техник ашиглалтын паспорт хөтлөөгүй байна.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Заяажаргал
7	Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Заяажаргал
8	Шатахууны зардлыг зорилтот түвшний төлөвлөгөөнөөс 1.3 сая төгрөгөөр хэтрүүлэн. шатахууны тооцоо бодож тайлан гаргаагүй.	1.3	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Заяажаргал
<b>Нийт дүн</b>		<b>44.4</b>			

# ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.